

**ХҮҮХДИЙН ХАМГААЛУУЛАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ  
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН, ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ  
ХОЛБООТОЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТАЙЛАН**

2023 оны 07 дугаар  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Сэдэв:** Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэгт заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Г.Амартүвшин, Т.Аубакир, Д.Батлут, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Н.Наранбаатар, Д.Өнөрболор, Б.Саранчимэг, Т.Энхтүвшин нарын гишүүнээс Улсын Их Хурлын даргад хандан 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн УИХ-03/4957 дугаар албан бичгээр Хяналтын сонсгол явуулах хүсэлтийг ирүүлсэн. Нийгмийн бодлогын байнгын хороо хүсэлтийг 2022 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлд заасны дагуу сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны 09 дүгээр тогтоолыг баталж, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмааг томилсон болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.2 дахь хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3 дахь хэсэгт заасны дагуу Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголын хүрээнд “Хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах” сэдэвт сонсголыг зохион байгуулах талаар тов, мэдээллийг 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сонсголд оролцогчдыг бүртгэсэн болно.

2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 14:00 цагт Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт заасны дагуу Байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь буюу Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ц.Идэрбат, Ц.Сандаг-Очир, Ж.Чинбүрэн, Д.Батлут, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг, Х.Булгантуяа нарын гишүүд хүрэлцэн ирснээр сонсголыг хүчинтэйд тооцож хяналтын сонсгол эхэлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйл, Нийтийн сонсголын тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар сонсгол зохион байгуулах болсон үндэслэл, зорилго, оролцогчдын ирц, сонсголын дэг, дараалал, сонсголд оролцогчдын эрх, үүргийг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцууллаа.

**Сонсголд:**

- Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг холбогдох төрийн байгууллагын албан тушаалтнууд;

- НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн зөн олон улсын байгууллага, Монгол Улсын Боловсролын Их Сургууль зэрэг байгууллагын судлаач;
- Монголын сургуулийн нийгмийн ажилтны холбоо, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төлөө Галт шувуу холбоо, Өсвөр үеийнхний хөгжлийн төв, Саран ээж нийгэмлэг, Манай гэр асрах төв зэрэг төрийн бус байгууллагын төлөөлөл болон иргэдийн төлөөлөл, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл зэрэг нийт 50 гаруй оролцогчид оролцсон болно.

**Нэг. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэгт заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын төлөөллөөс хийсэн мэдээлэл сонсох**

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэгт заасан хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрх, хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, хувийн мэдээлэл, орон байрны халдашгүй байдал хувийн орон зайгаа хамгаалуулах эрхийн хэрэгжилтийн талаар холбогдох төрийн байгууллагуудаас дараах мэдээллийг танилцууллаа. Үүнд:

**Нэгдүгээрт:** Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр хийсэн ажил, барьж байгаа бодлого, төлөвлөж байгаа ажлуудын талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Х.Хунан; */Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү./*

**Хоёрдугаарт:** Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэгт заасан хүүхдийн эрхийн талаарх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч Н.Өлзийхутаг; */Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-оос үзнэ үү./*

**Гуравдугаарт:** Хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчил, шалтгаан нөхцөл, хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн талаарх танилцуулгыг Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга цагдаагийн хошууч Г.Мөнхбаяр */Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 3-аас үзнэ үү./* нар тус тус танилцууллаа.

**Хоёр.Танилцуулга, мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдийн асуулт**

Сонсголын сэдэв, холбогдох байгууллагуудын мэдээлэл, танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хамтарсан багийн үйл ажиллагаа, хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, санхүүжилт хүртээмжтэй эсэх, хүүхэд хүчирхийлэлд өртөж байгаа шалтгаан нөхцөлийн талаар болон хүүхэд үл хайхрах хүчирхийлэлд өртөж байгаа талаар,

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын ажлын уялдаа холбоо ямар түвшинд байгаа, хүүхдийн хамгаалуулах эрх зөрчигдсөн талаар судалгаа хийсэн эсэх,

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут Хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчил, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн талаар болон хүүхдийн амиа хорлолттой холбоотой асуудлууд, гэмт хэрэгт холбогдсон шалтгаан нөхцөлийн талаар,

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Б.Жаргалмаа Гандантэгчэнлин хийдэд болсон Ламхай нартай холбоотой асуудал, өсвөр насны жирэмслэлт, Эрүүл мэндийн төвүүдийн хүүхдийн кабинетууд хангалттай ажиллаж чадахгүй байгаа талаар тус тус асуулт асууж, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сан, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг зэрэг байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтан хариулт өглөө.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1.4-т заасны дагуу хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Анужин хүний хөгжил, ухамсар, сэтгэл зүйн судалгаа хийх, хүнээ хөгжүүлэх талаар нийгмийн бүхий л салбарт соён гэгээрүүлэх, төлөвшүүлэх асуудалд онцгой анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Хүүхэд хамгааллын талаар гүйцэтгэх засаглал, салбарын байгууллагуудын ажлын уялдаа холбоогоог сайжруулж, үр дүнтэй ажиллах талаар үг хэлсэн болно.

Сонсголд оролцогч Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгийн тэргүүн Б.Мөнхжаргал нийгмийн ажилтнуудын ажиллах нөхцөл, цалин урамшуулалтын талаар, “Анар” зуслангийн захирал Б.Арсланбат хүүхдийн зуслангийн нийтлэг шаардлага стандартыг шинэчлэх, хүүхдэд хөдөлмөрийн дадал олгох талаар, Хүүхдийн эрхийн судлаач С.Энхтуяа хүүхдийн эрхийг хамгаалах тухай олон улсын эрх зүйн нэр томъёог дотоодын хууль, тогтоомжид зөв тусгаж, хэвшүүлэх талаар тус тус үг хэлсэн.

### **Гурав. Хяналтын сонсголын хаалт**

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Б.Жаргалмаа Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийг үндэслэн сонсголын тайланг Нийгмийн бодлогын байнгын хороонд танилцуулж, авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төслийг хэлэлцүүлэх саналыг хэлж сонсголыг хаасан.

### **Дөрөв.Хяналтын сонсголын нэгдсэн санал, дүгнэлт**

Хүүхдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээ тэгш, хүртээмжтэй, ялгамжгүй байх шаардлагатай бөгөөд хүүхэд бүр амьдарч байгаа газар, нөхцөл боломжоос үл хамааран нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй.

Монгол Улс хүүхэд хамгааллын хүрээнд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, хохирогч болсон хүүхдэд цогц үйлчилгээ үзүүлэх хүүхдийн тусламжийн утас, хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхдийн эрхийн улсын байцаагч зэрэг тусгайлсан бүтэц байгуулан хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэн, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа ч хэрэгжүүлэх явцад тулгарч байсан асуудал, бэрхшээл, эрх зүйн зохицуулалтын зарим тодорхойгүй байна.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголд оролцсон Улсын Их Хурлын гишүүд, бусад оролцогчдоос гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн дараах байдлаар танилцуулж байна. Үүнд:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хохирогч хамгааллын бүтэц, тогтолцооны зураглалыг гаргах, байгууллагуудын чиг үүргийн давхцалыг арилгаж, уялдаа холбоог хангах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;
2. Хамтарсан багийг чадавхжуулах, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үүргийг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хариуцуулах, сум, багуудад гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтны орон тоог тусгайлан бий болгож, хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх;
3. Хүүхэд хамгааллын чиглэлээр нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх, хүүхэд хамгааллын зөрчил болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад төрийн бус байгууллагын оролцоог дэмжих, сайн дурын хөтөлбөрийг үр дүнтэй эхлүүлэх;
4. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, хохирсон болон хүчирхийллийн бүхий л хэлбэрийг таслан зогсоох чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, гэмт хэрэг гарч буй шалтгаан нөхцөлийн талаар судалж, шаардлагатай арга хэмжээг авах;
5. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг гэмт хэрэгт холбогдсон, гэрч, хохирогч хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай нь ажиллах хуульд заасан чиг үүргийг эрчимжүүлэхэд анхаарах;
6. Хүүхэд, өсвөр үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах, холбогдох дүн шинжилгээ, судалгааг тогтмол хийж, хэрэгжилтийг хангаж ажиллах;
7. Орон нутгийн төсвийн тодорхой хувийг хүүхэд хамгааллын зардалд тусгах талаар санал боловсруулж, хууль тогтоомжид холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах;
8. Байнгын хорооны сар бүрийн хэлэлцэх асуудлын цаглаварт хүүхдийн эрхийг хамгаалах талаар тодорхой сэдэв, асуудлыг тусган, хэлэлцэж шийдвэр гаргах;
9. Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны стандартыг батлан гаргах, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийг хуулиар тогтоосон тус бүрийн чиг үүргийн дагуу ажиллуулах.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,  
СОНСГОЛ ДАРГАЛАГЧ**



**Б.ЖАРГАЛМАА**